130

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 06 сарын 22 өдөр Дугаар А/54 Улаанбаатар хот

Өргөмжит консулын тухай журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Өргөмжит консулын тухай журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад хэргийн яамны Консулын газрын захирал, нийт Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Өргөмжит консулын тухай журмыг шинэчлэн батлах тухай Гадаад хэргийн сайдын 2015 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/12 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Л.ПҮРЭВСҮРЭН

080210

131

Гадаад хэргийн сайдын 2016 оны
06 дугаар сарын 22-ны өдрийн
A/54 дугаар тушаалын хавсралт

ӨРГӨМЖИТ КОНСУЛЫН ТУХАЙ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл
Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар өргөмжит консулын тэргүүлсэн консулын байгууллагыг хилийн чанадад болон Монгол Улсад байгуулах, өргөмжит консулын үйл ажиллагааны чиглэл, эрх үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэ журмаар зохицуулаагүй харилцааг Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенц, Дипломат албаны тухай хууль болон холбогдох Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
ГАДААД УЛСАД СУУХ МОНГОЛ УЛСЫН ӨРГӨМЖИТ КОНСУЛ

2 дугаар зүйл
Өргөмжит консул

2.1. Өргөмжит консул нь дараахь зэрэглэлтэй байна:

2.1.1. өргөмжит ерөнхий консул;
2.1.2. өргөмжит консул.

2.2. Өргөмжит консул нь Монгол Улсын болон хүлээн авагч улсын иргэн байж болно.

2.3. Өргөмжит консул нь:

2.3.1. гадаад улсын төрийн албан хаагч байж болохгүй;
2.3.2. өөр улсын өргөмжит консулын албыг давхар хашихгүй;
2.3.3. өргөмжит консулын чиг үүргийг гүйцэтгэсний төлөө Монгол Улсаас аливаа цалин хөлс, үйл ажиллагааны зардал шаардахгүй;
2.3.4. 70-аас доош настай байх бөгөөд онцгой тохиолдолд 70-аас дээш настай байж болно.

3 дугаар зүйл
Өргөмжит консулыг томилох

3.1. Хилийн чанадад Монгол Улсын өргөмжит консулаар ажиллах хүсэлтэй хүн хүсэлтээ Монгол Улсын гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн (цаашид "Монгол Улсын Гадаад хэргийн сайд" гэх)-ий нэр дээр бичгээр гаргаж,

дараахь материалыг хавсарган холбогдох Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газарт хүргүүлнэ. Дипломат төлөөлөгчийн газар байдаггүй бол Монгол Улсын гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид "Монгол Улсын Гадаад хэргийн яам" гэх)-ын Консулын газар (цаашид "Консулын газар" гэх)-т ирүүлнэ:

3.1.1. намтар (1 дүгээр хавсралт);
3.1.2. өргөмжит консулаар ажиллах үйл ажиллагааны хөтөлбөр;
3.1.3. хүлээн авагч улсын улс төр, бизнес, соёлын салбарын нөлөө бүхий хоёроос доошгүй хүний дэмжсэн захидал;
3.1.4. ял шийтгэлтэй эсэх талаарх цагдаагийн байгууллагын тодорхойлолт;
3.1.5. санхүүгийн чадавхийг нотолсон банкны тодорхойлолт;
3.1.6. өргөмжит консулын газар байрлах газарт тогтмол оршин сууж, үйл ажиллагаа явуулдаг болохыг нотлох бичиг баримт.

Тайлбар: Энэ журамд заасан "холбогдох Дипломат төлөөлөгчийн газар" гэж тухайн өргөмжит консулын газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах Элчин сайдын яамыг ойлгоно.

3.2. Энэ журмын 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу өргөмжит консулаар ажиллах хүсэлтэй хүний ирүүлсэн материалыг хүлээн авсан Дипломат төлөөлөгчийн газар 30 хоногийн дотор нэр дэвшигчийн талаарх тухайн газрын тодорхойлолт, саналын хамт Консулын газарт ирүүлнэ.

3.3. Консулын газар өргөмжит консулаар ажиллах 1-2 нэр дэвшигчийн хүсэлт, материалыг хүлээж авсны дараагаар Монгол Улсын өргөмжит консулын тэргүүлсэн консулын байгууллага байгуулах, консулын тойргийг тогтоох, өргөмжит консул томилох, түүнд виз олгох эрх өгөх асуудлаар Монгол Улсын Гадаад хэргийн яамны хоёр талын харилцааны асуудал эрхэлсэн газар (цаашид "Чиглэлийн газар" гэх), холбогдох бусад байгууллага, хүсэлтээ Консулын газарт шууд гаргасан тохиолдолд холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын саналыг авсны үндсэн дээр Монгол Улсын Гадаад хэргийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

3.4. Монгол Улсын Гадаад хэргийн сайдын зөвлөлийн хуралдаанаас дэмжлэг авсан нэр дэвшигчийг Монгол Улсын Гадаад хэргийн сайдын тушаалаар (2 дугаар хавсралт) өргөмжит консулаар томилно.

Хэрэв хүлээн авагч улс өргөмжит консул томилоход урьдчилсан зөвшөөрөл өгдөг журамтай бол урьдчилсан зөвшөөрлийг авсны дараа тушаал гаргана.

3.5. Өргөмжит консулыг хоёр жилийн хугацаагаар томилох бөгөөд хүлээн авагч улс экзекватур олгосон өдрөөс эхлэн томилолтын хугацааг нь тооцно.

4 дүгээр зүйл
Патент

4.1. Өргөмжит консул томилох тухай Монгол Улсын Гадаад хэргийн сайдын тушаалыг үндэслэн өргөмжит консулд патент олгоно.

4.2. Патентад өргөмжит консулын овог нэр, зэрэглэл, консулын тойрог, байрлах газрыг заана (3 дугаар хавсралт).

4.3. Өргөмжит консулын консулын тойргийг хүлээн авагч улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамны Консулын хэлтэс, Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газрын консулын тойрогтой давхардуулахгүй байх зарчим баримтална.

4.4. Патентыг гурван хувь үйлдэж нэгийг нь хүлээн авагч улсын Гадаад хэргийн яаманд хүргүүлж, нөгөөг нь өргөмжит консулд гардуулж, үлдэх хувийг нь архивт хадгална.

5 дугаар зүйл
Өргөмжит консул үүрэгт ажилдаа орох

5.1. Хүлээн авагч улс экзекватур олгосон өдрөөс эхлэн өргөмжит консул үүрэгт ажилдаа орсонд тооцно.

5.2. Монгол Улсын Гадаад хэргийн яам өргөмжит консулд "Монгол Улсын өргөмжит консул" гэж монгол, англиар бичсэн дугаар бүхий тамга гардуулж өгнө.

5.3. Өргөмжит консул албан байр, уналгадаа Монгол Улсын төрийн далбаа мандуулж, албан байрандаа "Монгол Улсын Өргөмжит консулын газар" гэсэн монгол хэлээрх, "Honorary Consulate of Mongolia" гэсэн англи хэлээрх бичвэртэй хаяг байрлуулна (4 дүгээр хавсралт).

5.4. Өргөмжит консулд томилолтын хугацаанд нь хэрэглэгдэх Консулын газрын захирлын гарын үсэг, тэмдгээр баталгаажсан Өргөмжит консулын үнэмлэхийг олгоно (5 дугаар хавсралт).

5.5. Өргөмжит консул энэ журмын 5 дугаар зүйлийн 5.4-т заасны дагуу олгосон үнэмлэхийг чиг үүргээ гүйцэтгэх болон Монгол Улсын Гадаад хэргийн яаманд нэвтрэх зэрэг зорилгоор ашиглана.

Тайлбар: Өргөмжит ерөнхий консулын үнэмлэхний хувьд өргөмжит ерөнхий консулын үнэмлэх (англиар "Identification Card of Honorary Consul General") гэсэн бичилтийг хийнэ. MN ("Mongolia" үгийн товчлол) тэмдэглэгээг гадаад улсад суух Монгол Улсын өргөмжит консулын үнэмлэхний дугаарын эхэнд хэрэглэнэ.

5.6. Өргөмжит консулын албан захидал харилцаа хэвлэмэл хуудас дээр явагдана (6 дугаар хавсралт).

6 дугаар зүйл
Өргөмжит консулын эрх ямба, дархан эрх

6.1. Өргөмжит консулын эрх ямба, дархан эрх нь Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенцийн Гуравдугаар бүлэг, олон улсын зан заншлын хэм хэмжээ, хүлээн авагч улсын хууль тогтоомжоор тодорхойлогдоно.

7 дугаар зүйл
Өргөмжит консулын чиг үүрэг

7.1. Өргөмжит консул Монгол Улсыг хилийн чанадад сурталчилан таниулах, соёл, урлагийн арга хэмжээ, үзэсгэлэн зохион байгуулах үйл ажиллагааг идэвхитэй явуулна.

7.2. Өргөмжит консул Монгол Улс, хүлээн авагч улсын хооронд худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, соёл, боловсрол, шинжлэх ухаан, технологийн зэрэг бүх салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

7.3. Өргөмжит консул Монгол Улсын үндэсний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээн авагч улсад сурталчилан таниулах, гадаад шинэ зах зээл нээх, экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, техник технологи нэвтрүүлэх чиглэлээр ажиллана.

7.4. Өргөмжит консул хүлээн авагч улсын худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, соёл, боловсрол, шинжлэх ухаан, технологийн зэрэг салбарт болж буй үйл явдал, нөхцөл байдлыг хууль ёсны арга замаар судалж, энэ талаар Монгол Улсын Гадаад хэргийн яам болон холбогдох Дипломат төлөөлөгчийн газарт мэдээлэл өгнө.

7.5. Өргөмжит консул консулын тойрогтоо Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр дор дурдсан чиг үүргийг гүйцэтгэнэ:

7.5.1. иргэнийг саатуулсан, баривчилсан, шүүхээс ял шийтгэл оногдуулсан, хуулийн этгээдийн эсрэг гомдол гаргаж шүүхэд хандсан тухай бүр холбогдох Дипломат төлөөлөгчийн газарт болон Консулын газрын өргөмжит консулын асуудал эрхэлсэн консулын ажилтанд нэн даруй мэдэгдэх;

7.5.2. иргэн, хуулийн этгээдийг төлөөлөх, хууль ёсны эрх ашгийг нь хамгаалах;

7.5.3. удаан хугацаагаар хорих ял эдэлж буй иргэнийг жилд нэгээс доошгүй удаа эргэх;

7.5.4. иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх талаар шаардлагатай арга хэмжээ авах;

7.5.5. иргэн нас барсан тохиолдолд энэ тухай холбогдох Дипломат төлөөлөгчийн газарт болон Консулын газрын өргөмжит консулын асуудал эрхэлсэн консулын ажилтанд нэн даруй мэдэгдэх, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүнийг нь тодруулах, шарилыг нь хадгалуулах, цагдаагийн болон бусад байгууллагын тодорхойлолтыг гаргуулах, шүүхэд нэхэмжлэл гаргах, нас барсан иргэний үнэт зүйл, бичиг баримтыг хадгалах, шарил буюу чандрыг Монгол Улсад хүргүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

7.5.6. эцэг эхийн асрамжгүй, насанд хүрээгүй иргэнд асран хамгаалагч, эрүүл мэндийн байдлаас шалтгаалан эрх эдэлж, үүрэг хүлээх чадваргүй болсон насанд хүрсэн иргэнд харгалзан дэмжигч олж өгөх;

7.5.7. иргэний өвлөх эд хөрөнгийн талаар мэдээлэл олбол холбогдох Дипломат төлөөлөгчийн газарт болон Консулын газрын өргөмжит консулын асуудал

эрхэлсэн консулын ажилтанд мэдэгдэж, өвлөх асуудлыг шийдтэл эд хөрөнгийг хамгаалах;

7.5.8. хүлээн авагч улсад нь дайны болон онц байдал тогтоосон, байгалийн гэнэтийн аюул, гамшиг бий болсон, хүн, малын гаралтай гоц халдварт өвчин гарсан, зэвсэгт мөргөлдөөн, дотоодын бослого, үймээн, террорист халдлага гарсан тохиолдолд иргэнд бололцоотой бүхий л дэмжлэг туслалцаа үзүүлэх;

7.5.9. олон улсын хүчин төгөлдөр гэрээний дагуу, хэрэв тийм гэрээгүй бол хүлээн авагч улсын хууль, журамд үл харшлах аливаа өөр журмаар шүүхийн болон шүүхийн бус бичиг баримт дамжуулах, Монгол Улсын шүүхийн даалгавар буюу шүүхэд зориулан мэдүүлэг авах даалгавар гүйцэтгэх;

7.5.10. иргэн, хуулийн этгээдэд хүлээн авагч улсын хууль тогтоомж, зан заншил болон тэдний эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх;

7.5.11. иргэдийн нийгэмлэг, үүсгэл санаачилгыг дэмжиж хамтран ажиллах;

7.5.12. иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд Монгол Улсын болон хүлээн авагч улсын төрийн бус байгууллага, хүний эрхийн болон өмгөөллийн байгууллагатай хамтран ажиллах.

7.6. Энэ журмын 3 дугаар зүйлийн 3.3-т заасан тушаалаар эрх олгосон бол өргөмжит консул нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 17.3-т заасны дагуу Консулын газраас олгосон визийн зөвшөөрлийн дагуу "O", "B", "J" ангиллын 30 хүртэлх хоногийн виз, "D", "A" ангиллын виз, Монгол Улсын иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон визийн зөвшөөрлийн дагуу бусад ангиллын визийг олгоно.

7.7. Өргөмжит консул нь Монгол Улсын холбогдох байгууллагын хүсэлтээр хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас баримт бичиг нэхэмжлэн гаргуулна.

7.8. Өргөмжит консул нь хүлээн авагч улсад хүн, малын гаралтай гоц халдварт өвчин гарсан, бусад онцгой байдал үүссэн тохиолдолд энэ талаар холбогдох Дипломат төлөөлөгчийн газарт болон Консулын газрын өргөмжит консулын асуудал эрхэлсэн консулын ажилтанд нэн даруй мэдэгдэж, консулын тойрогт байгаа болон тус тойрогт зорчих Монгол Улсын иргэдэд сэрэмжлүүлэг өгнө.

7.9. Консулын үйлчилгээний төлбөр, хураамжийг Монгол Улсын хууль тогтоомжид заасан тарифын дагуу, холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын тарифтай адил байдлаар хүлээн авагч улсын болон чөлөөтэй хөрвөх валютаар авч Монгол Улсын Гадаад хэргийн яамнаас мэдэгдсэн дансанд шилжүүлж, энэ тухайгаа Монгол Улсын Гадаад хэргийн яамны санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн нэгжид дараа улирлын эхний сарын 10-ны өдөр дотор тайлагнаж, хувийг холбогдох Дипломат төлөөлөгчийн газарт болон Консулын газрын өргөмжит консулын асуудал эрхэлсэн консулын ажилтанд ирүүлж байна.

7.10. Өргөмжит консул нь иргэний бүртгэл хөтлөхгүй бөгөөд нотариатын үйлдэл хийхгүй.

8 дугаар зүйл
Өргөмжит консул чиг үүргээ гүйцэтгэх

8.1. Өргөмжит консул чиг үүргээ консулын тойргийн дотор гүйцэтгэнэ. Онцгой тохиолдолд хүлээн авагч улс зөвшөөрснөөр консулын тойргоос гадна чиг үүргээ гүйцэтгэж болно.

8.2. Өргөмжит консул чиг үүргээ гүйцэтгэхдээ Монгол Улсын болон хүлээн авагч улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний заалтыг баримтална. Хүлээн авагч улсын хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа эрхлэхгүй.

8.3. Өргөмжит консул чиг үүргээ гүйцэтгэхдээ Монгол Улсын нэр хүндийг эрхэмлэн дээдэлнэ.

8.4. Өргөмжит консул эрхэлж буй бичиг хэргээ Монгол Улсын архивын хууль тогтоомжийн дагуу хадгалж, өргөмжит консулын архив бүрдүүлэн бүрэн бүтэн байдлыг хангана.

8.5. Өргөмжит консулын үйл ажиллагаанд хамаарах бүхий л бичиг баримт, тухайлбал өргөмжит консулд тусгайлан олгосон чиглэл, удирдамжийг зөвшөөрөлгүйгээр тараах, хэвлэн нийтлэх, бусдад дамжуулахыг хориглоно.

8.6. Өргөмжит консул Монгол Улсын Гадаад хэргийн яам, холбогдох Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газрын өргөмжит консулын асуудал эрхэлсэн консулын ажилтантай өдөр тутмын харилцаагаа www.consuls.net, www.consul.mn интернет сүлжээ, чат, утас, факс, и-мэйл ашиглан явуулна.

9 дүгээр зүйл
Өргөмжит консулыг удирдан ажиллуулах

9.1. Холбогдох Дипломат төлөөлөгчийн газар нь өргөмжит консулыг харилцаа, хамтын ажиллагааны бодлогын асуудлаар удирдах бөгөөд жилийн ажлын тайланг нь авч, энэ журмын 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэн жилийн ажлын тайландаа тусгана.

9.2. Өргөмжит консулын жилийн ажлын тайлан, үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг Чиглэлийн газар нь харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар, Консулын газар нь иргэд, консулын асуудлаар тус тус дүгнэж, холбогдох Дипломат төлөөлөгчийн газраар уламжлан хариу зааварлана.

9.3. Консулын газрын өргөмжит консулын асуудал эрхэлсэн консулын ажилтан болон холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын өргөмжит консулын асуудал эрхэлсэн ажилтан өргөмжит консулын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах бөгөөд захиргааны асуудлаар шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

9.4. 6 жилээс дээш хугацаанд идэвхи санаачлагатай, үр бүтээлтэй ажилласан өргөмжит консулыг холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын саналыг үндэслэн Монгол Улсын одон, медалиар шагнуулахаар нэрийг нь дэвшүүлж болно.

10 дугаар зүйл
Өргөмжит консулын томилолтын хугацааг сунгах

10.1. Өргөмжит консул томилолтын хугацаагаа сунган үргэлжлүүлэн ажиллах хүсэлтэй бол энэ тухай хүсэлтээ дараагийн хоёр жилд ажиллах үйл ажиллагааны хөтөлбөрийн хамт Консулын газарт томилолтын хугацаа дуусахаас 2 сарын өмнө ирүүлнэ.

10.2. Өргөмжит консул энэ журмын 10 дугаар зүйлийн 10.1-д заасан хугацаанд томилолтын хугацаагаа сунгуулах тухай хүсэлтээ ирүүлээгүй нь түүнийг чөлөөлөх үндэслэл болно.

10.3. Консулын газар энэ журмын 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу ирүүлсэн хүсэлттэй холбогдуулан тухайн өргөмжит консулын томилолтын хугацааг сунгах асуудлаар Чиглэлийн газар, холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын саналыг авсны үндсэн дээр Монгол Улсын Гадаад хэргийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

10.4. Өргөмжит консулын томилолтын хугацааг Монгол Улсын Гадаад хэргийн сайдын зөвлөлийн хуралдаанаас сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд өргөмжит консулын томилолтын хугацааг хоёр жилээр сунгах тухай Монгол Улсын Гадаад хэргийн сайдын тушаал гаргана.

11 дүгээр зүйл
Өргөмжит консулын зэрэглэл, тойргийг өөрчлөх

11.1. Өргөмжит консулын зэрэглэл, тойргийг өөрчлөх талаар өргөмжит консулаас, эсхүл холбогдох Дипломат төлөөлөгчийн газраас санал ирүүлсэн тохиолдолд Консулын газар энэ асуудлаар Чиглэлийн газар, өргөмжит консул хүсэлтээ шууд ирүүлсэн тохиолдолд холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын саналыг авсны үндсэн дээр Монгол Улсын Гадаад хэргийн сайдад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

11.2. Энэ журмын 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу танилцуулсан өргөмжит консулын зэрэглэл, тойргийг өөрчлөх саналыг дэмжсэн тохиолдолд консулын зэрэглэл, консулын тойргийг өөрчлөх тухай Монгол Улсын Гадаад хэргийн сайдын тушаал гаргана.

Хэрэв хүлээн авагч улс урьдчилсан зөвшөөрөл өгдөг журамтай бол урьдчилсан зөвшөөрлийг авсны дараа тушаал гаргана.

11.3. Энэ журмын 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан Монгол Улсын Гадаад хэргийн сайдын тушаалыг үндэслэн өргөмжит консулын патентыг шинэчилж олгоно.

12 дугаар зүйл
Өргөмжит консулын үйл ажиллагааг дуусгавар болгох

12.1. Өргөмжит консулын томилолтын хугацаа дууссан бөгөөд томилолтын хугацаагаа сунгуулах тухай хүсэлтээ энэ журмын 10 дугаар зүйлийн 10.1-д заасан хугацаанд гаргаагүй бол түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлнө.

12.2. Консулын газар дараахь үндэслэлээр өргөмжит консулыг томилолтын хугацаанаас нь өмнө чөлөөлөх асуудлыг өөрийн саналаар болон Чиглэлийн газар, холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын саналыг үндэслэн Монгол Улсын Гадаад хэргийн сайдад танилцуулж, шийдвэрлүүлнэ:

12.2.1. хүлээн авагч улс экзекватурыг цуцалсан буюу түүнийг өргөмжит консул гэж тооцохоо больсон тухайгаа мэдэгдсэн;
12.2.2. томилогдсоноосоо хойш өргөмжит консул тодорхой үр бүтээлтэй ажил хийгээгүй, эсхүл огт үйл ажиллагаа явуулаагүй;
12.2.3. өргөмжит консул үүргээ биелүүлж чадахгүй болсон шалтгаанаа дурдсан өргөдлөө Монгол Улсын Гадаад хэргийн сайдад гаргасан;
12.2.4. өргөмжит консул төрийн албанд шилжсэн, өөр улсын өргөмжит консулаар томилогдсон;
12.2.5. консулын үйлчилгээний төлбөр, хураамжийг Монгол Улсын Гадаад хэргийн яамнаас мэдэгдсэн дансанд шилжүүлээгүй гурван улирал хэтэрсэн.

12.3. Энэ журмын 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу өргөмжит консулын томилолтын хугацаа нь дуусгавар болсон, мөн 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу танилцуулсан өргөмжит консулыг хугацаанаас нь өмнө чөлөөлөх саналыг дэмжсэн тохиолдолд өргөмжит консулыг чөлөөлөх тухай Монгол Улсын Гадаад хэргийн сайдын тушаал гаргана.

12.4. Энэ журмын 12 дугаар зүйлийн 12.3-т заасан Монгол Улсын Гадаад хэргийн сайдын тушаалыг үндэслэн өргөмжит консулыг чөлөөлсөн талаар хүлээн авагч улсын Гадаад хэргийн яаманд ноот бичгээр мэдэгдэнэ.

12.5. Өргөмжит консулыг үүрэгт ажлаас нь чөлөөлмөгц холбогдох Дипломат төлөөлөгчийн газар:

12.5.1. өргөмжит консулын ашиглаж байсан тамга, визийн наадаг хуудас, бичиг баримт, бусад материалыг баримтаар хүлээн авч Консулын газарт ирүүлнэ,
12.5.2. консулын үйлчилгээний төлбөр, хураамжтай холбоотой санхүүгийн тооцоог хийж, холбогдох тайланг Монгол Улсын Гадаад хэргийн яамны санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн нэгжид ирүүлнэ.

13 дугаар зүйл
Өргөмжит консулуудын уулзалт

13.1. Өргөмжит консулуудын уулзалтыг хоёр жил тутамд хийж, дараахь асуудлыг хэлэлцэнэ:

13.1.1. дараагийн хоёр жилийн үйл ажиллагааны үндсэн чиглэл;

13.1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой асуудал.

13.2. Консулын газар, Чиглэлийн газар өргөмжит консулуудын уулзалтын үеэр өргөмжит консулуудад ажил төрлийн зааварчилга өгч, шинээр гарсан хууль тогтоомжийн талаар танилцуулна.

13.3. Өргөмжит консулуудын уулзалтын үр дүнгийн талаар протокол гаргаж, тодорхой төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
МОНГОЛ УЛСАД СУУХ ГАДААД УЛСЫН ӨРГӨМЖИТ КОНСУЛ

14 дүгээр зүйл
Өргөмжит консулын тэргүүлсэн консулын байгууллагыг байгуулах

14.1. Монгол Улсад өргөмжит консулын тэргүүлсэн консулын байгууллага байгуулах хүсэлтээ тухайн улсын Гадаад хэргийн яам Монгол Улсын Гадаад хэргийн яаманд ирүүлэх бөгөөд дараахь мэдээллийг тусгасан байна:

14.1.1. консулын байгууллагын зэрэглэл, консулын тойрог;
14.1.2. өргөмжит консулаар томилох хүний овог нэр, намтар;
14.1.3. консулын байгууллагын байрлах газар, хаяг, холбоо барих утас, факс, и-мэйл;
14.1.4. консулын байгууллага паспорт, виз, буцах үнэмлэх болон иргэний бүртгэлийн бичиг баримт олгох эсэх талаарх мэдээлэл;
14.1.5. консулын байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах Дипломат төлөөлөгчийн газар.

14.2. Өргөмжит консулын тэргүүлсэн консулын байгууллагыг зөвхөн Монгол Улсын нийслэлд байгуулна.

14.3. Нэг улсаас Монгол Улсад байгуулах өргөмжит консулын тэргүүлсэн консулын байгууллагын тоог хязгаарлахгүй, харин консулын тойргийг давхардуулахгүй.

14.4. Энэ журмын 14 дүгээр зүйлийн 14.1-т заасан хүсэлтийг үндэслэн Консулын газар Чиглэлийн газар болон холбогдох Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрын саналыг авсны үндсэн дээр гадаад улсын өргөмжит консулын тэргүүлсэн консулын байгууллага байгуулах, өргөмжит консул томилох, түүнд экзекватур олгох асуудлыг Монгол Улсын Гадаад хэргийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

14.5. Монгол Улсын Гадаад хэргийн сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн томилогч улсын Гадаад хэргийн яаманд ноот бичгээр хариу мэдэгдэнэ.

14.6. Монгол Улсад суух гадаад улсын өргөмжит консулд томилолтын хугацаанд нь хэрэглэгдэх Консулын газрын захирлын гарын үсэг, тэмдгээр баталгаажсан Өргөмжит консулын үнэмлэх олгоно (8 дугаар хавсралт).

Тайлбар: Өргөмжит ерөнхий консулын үнэмлэхний хувьд өргөмжит ерөнхий консулын үнэмлэх (англиар "Identification Card of Honorary Consul General") гэсэн бичилтийг хийнэ. HC ("Honorary Consul" үгийн товчлол) тэмдэглэгээг Монгол Улсад суух гадаад улсын өргөмжит консулын үнэмлэхний дугаарын эхэнд хэрэглэнэ.

15 дугаар зүйл
Өргөмжит консул

15.1. Өргөмжит консулын зэрэглэлийг томилогч улс тогтооно.

15.2. Өргөмжит консул нь томилогч улсын болон Монгол Улсын иргэн байж болно.

15.3. Өргөмжит консул нь:

15.3.1. Монгол Улсын төрийн албан хаагч байж болохгүй;
15.3.2. гуравдагч улсын өргөмжит консулын албыг давхар хашихгүй.

15.4. Томилогч улс дипломат шугамаар бичгээр мэдэгдэж зөвшөөрөл авсны үндсэн дээр өргөмжит консулын зэрэглэл, консулын тойргийг өөрчилж болно.

16 дугаар зүйл
Экзекватур

16.1. Томилогч улсаас олгосон патентыг үндэслэн өргөмжит консулд экзекватур олгоно (7 дугаар хавсралт).

16.2. Экзекватур олгосон өдрөөс өргөмжит консул үүрэгт ажилдаа орох эрхтэй болно.

16.3. Энэ журмын 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу өргөмжит консулын зэрэглэл, консулын тойргийг өөрчилсөн бол экзекватурыг шинэчилж олгоно.

17 дугаар зүйл
Экзекватурыг хүчингүй болгох

17.1. Томилогч улсын Гадаад хэргийн яам өргөмжит консулын бүрэн эрхийг дуусгавар болгосноо Монгол Улсын Гадаад хэргийн яаманд мэдэгдвэл түүний экзекватурыг хүчингүй болгоно.

17.2. Дараахь тохиолдолд экзекватурыг хүчингүй болгох асуудлыг томилогч улсын Гадаад хэргийн яаманд тавина:

17.2.1. өргөмжит консулын үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж, зан заншил, үндэсний аюулгүй байдалд нийцэхгүй байвал;
17.2.2. өргөмжит консул Монгол Улсын төрийн албан хаагч болвол;
17.2.3. өргөмжит консул гуравдагч улсын өргөмжит консулын албыг хаших болвол.

18 дугаар зүйл
Өргөмжит консулын чиг үүрэг

18.1. Өргөмжит консул нь Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенцын 5 дугаар зүйлд заасан болон томилогч улсаас хүлээлгэсэн консулын чиг үүргийг гүйцэтгэнэ.

18.2. Өргөмжит консул томилогч улс, Монгол Улсын хооронд худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, соёл, боловсрол, шинжлэх ухаан, технологийн зэрэг бүх салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

18.3. Өргөмжит консул чиг үүргээ консулын тойргийн дотор гүйцэтгэнэ. Онцгой тохиолдолд Монгол Улсын Гадаад хэргийн яамны зөвшөөрснөөр консулын тойргийн гадна чиг үүргээ гүйцэтгэж болно.

18.4. Өргөмжит консул чиг үүргээ гүйцэтгэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний заалтыг баримтална. Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа эрхлэхгүй.

18.5. Өргөмжит консул албан байр, уналгаа консулын чиг үүрэгт үл нийцэх зорилгоор ашиглахгүй.

19 дүгээр зүйл
Өргөмжит консулын эрх ямба, дархан эрх

19.1. Өргөмжит консулын эрх ямба, дархан эрх нь Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенцийн Гуравдугаар бүлэг, олон улсын эрх зүйн зан заншил, Монгол Улсын хууль тогтоомжоор тодорхойлогдоно.

19.2. Өргөмжит консул эрх ямба, дархан эрхээ консулын чиг үүргээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

- - - o o O o o - - -

Гадаад улсад суух Монгол Улсын өргөмжит консулд нэр дэвшигчийн намтрын маягтын загвар

Хувь хүний талаарх мэдээлэл	
Овог нэр:	Зураг
Төрсөн огноо, газар:	
Хүйс:	
Иргэншил:	
Утас: Факс: Гар утас: И-мэйл:	
Байнга оршин суугаа газрын хаяг:	

Гэр бүлийн байдал (зөвхөн хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдийг бичнэ)		
Нэр дэвшигчийн хэн болох	Овог, нэр	Төрсөн огноо:
		Төрсөн огноо:

Боловсрол				
Сургуулийн нэр	Төгссөн он	Мэргэжил	Боловсрол, эрдмийн зэрэг	Диплом, гэрчилгээний дугаар
1.				
2.				
3.				
4.				

Хөдөлмөр эрхлэлт		
Хугацаа	Байгууллага	Албан тушаал
1.		
2.		
3.		

ТББ-ын болон олон нийтийн сонгуульт ажил		
Хугацаа	Байгууллага	Албан тушаал
Сайшаал шагнал		

Үйл ажиллагааны тухай		
Байгууллага, компанийн нэр	Хаяг: Утас: Факс: И-мэйл	Үйл ажиллагааны чиглэл
Салбар байгууллага, компаниуд	Үйл ажиллагаа явуулдаг орон, бүс нутаг	

CV of Candidate applied for Honorary Consul of Mongolia in foreign countries

Personal information	
Family Name:	Photo
Given name:	
Date of Birth, Place:	
Gender:	
Citizenship:	
Tel: Fax: Mobile: E-mail:	
Address of permanent residence:	

Information of family members (only those in the household)		
Relationship to the candidate	Family and given names	Date of Birth:
		Date of Birth:

Education				
Educational institutions	Year of graduation	Major	Education, academic degree	Registration number of diploma and certificate
1.				
2.				
3.				
4.				

Work experience		
Period	Organization	Position
1.		
2.		
3.		

Membership of NGOs and other elected positions		
Period	Organization	Position
Award and honor		

Current Activities		
Name of the organization or company	Address: Tel: Fax: E-mail:	Field of activities:
Branch of the organization or company if any:	Country or region of its operation:	

Өргөмжит консулын тухай журмын
2 дугаар хавсралт

Гадаад улсад суух Монгол Улсын Өргөмжит консул томилох тухай Монгол Улсын Гадаад хэргийн сайдын тушаалын загвар

Өргөмжит консул томилох тухай

Дипломат албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, Өргөмжит консулын тухай журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг болон Гадаад хэргийн сайдын зөвлөлийн 201... оны ... дугаар сарын ....-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ..... Улс (консулын тойргийг тодорхой тусгах)-д суух Монгол Улсын Өргөмжит консулаар .....Улсын иргэн .....-г виз олгох эрхгүй (виз олгох эрхтэйгээр томилсон бол эрхтэйгээр гэж бичих)-ээр хоёр жилийн хугацаагаар томилсугай.

2. .....- ыг томилсон тухай Патентыг ..... Улсын Гадаад хэргийн яаманд хүргүүлж, түүнд Экзекватур олгосон даруйд үүрэгт ажилд нь оруулахыг Консулын газрын захирал ....., ... Элчин сайд ..... нарт үүрэг болгосугай.

/гарын үсэг/ ГАДААД ХЭРГИЙН САЙД
/тамга/

Өргөмжит консулын тухай журмын
3 дугаар хавсралт

Гадаад улсад суух Монгол Улсын өргөмжит консулд олгох патентын загвар

The Ministry of Foreign Affairs of Mongolia presents its compliments to the Ministry of Foreign Affairs of ..... and with reference to Articles 3, 10 and 11 of the Vienna Convention on Consular Relations, has the honour to present this Consular Commission appointing ..... as Honorary Consul of Mongolia to ..... in the city of ..... with jurisdiction over .....

The appointment will be for an initial period of two years and the Honorary Consul will conduct consular activities under the guidance of the Embassy of Mongolia in .....

The Ministry of Foreign Affairs of Mongolia kindly requests the esteemed Ministry of Foreign Affairs to recognize the capacity of ..... as Honorary Consul of Mongolia to ..... **in the city of .....** and to issue to him/her the Exequatur in order to enable him/her to carry out the consular duties.

The Ministry of Foreign Affairs of Mongolia also requests the Government and all the authorities of ..... to render assistance and support to his/her activity and to record all the facilities, privileges and immunities due to him/her by virtue of her office in accordance with the provisions of the Vienna Convention on Consular Relations.

The Ministry of Foreign Affairs of Mongolia avails itself of this opportunity to renew to the Ministry of Foreign Affairs of ..... the assurances of its highest consideration.

Ulaanbaatar,

" " Month, year

MINISTRY OF FOREIGN AFFAIRS OF
.....
.....

Өргөмжит консулын тухай журмын
4 дүгээр хавсралт

Гадаад улсад суух Монгол Улсын Өргөмжит консулын газрын
хаягны загвар

МОНГОЛ УЛСЫН ӨРГӨМЖИТ КОНСУЛЫН ГАЗАР

HONORARY CONSULATE OF MONGOLIA

Өргөмжит консулын тухай
журмын 5 дугаар
хавсралт

Гадаад улсад суух Монгол Улсын өргөмжит консулын үнэмлэхний загвар



Өргөмжит консулын тухай журмын
6 дугаар хавсралт

MONGOLIA

HONORARY CONSULATE

Address of the Honorary Consulate

Tel:
Fax:
E-mail

Өргөмжит консулын тухай журмын
7 дугаар хавсралт

Гадаад улсаас Монгол Улсад суух Өргөмжит консулд
олгох экзекватурын загвар

ҮҮНИЙГ ҮЗҮҮЛЭГЧ
Овог, нэр

Монгол Улсын Гадаад хэргийн яам ..... Улсын Гадаад хэргийн Сайдын ..... оны .. дугаар сарын ..-ны өдрийн консулын патентийг үндэслэн ..... Улсаас Монгол Улсад суух Өргөмжит консул болохыг үүгээр нотолж байна.

Ноён/хатагтай ..... консулын тойрогт Монгол Улс (консулын тойргийг тодорхой тусгах)-ыг хамааруулах болсныг үүгээр зарлан мэдэгдэж байна.

Ноён/хатагтай ..... Өргөмжит консулын чиг үүргийг гүйцэтгэхдээ эдлэх эрх ямба, дархан эрх нь Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенцийн гуравдугаар бүлэг, олон улсын эрх зүйн зан заншил, Монгол Улсын хууль тогтоомжоор тодорхойлогдоно.

.....

Гадаад хэргийн сайд

Мөнийг айлтгасан,

.....

Консулын газрын захирал

..... оны .... дугаар сарын “ ”

Улаанбаатар хот

Sample of an exequatur to be issued to the Honorary Consul of Foreign Countries to Mongolia

THE BEARER

Surname, name

The Ministry of Foreign Affairs of Mongolia hereby confirms that according to the Consular Commission issued by the Minister for Foreign Affairs of ..... , dated on ....., Mr/Mrs ..... shall act in the capacity of Honorary Consul of ..... to Mongolia.

It has also been announced that ..... of Mongolia (territories of consular district shall be specified) are covered by Mr/Mrs ..... 's Consular district

During his appointment, Mr/Mrs ..... shall enjoy the privileges and immunities which are regulated by the Chapter 3 of the Vienna Convention on Consular relations, effective laws and regulations of Mongolia and international customary law.

.....

Minister for Foreign Affairs of Mongolia

Countersigned,

.....

Director of Consular Department

Month " ", Year

Ulaanbaatar

157

Өргөмжит консулын тухай
журмын 8 дугаар
хавсралт

Монгол Улсад суух гадаад улсын өргөмжит консулын үнэмлэхний загвар

Монгол Улсын Гадаад хэргийн яам Ministry of Foreign Affairs of Mongolia

ӨРГӨМЖИТ КОНСУЛЫН ҮНЭМЛЭХ
IDENTIFICATION CARD OF HONORARY CONSUL

Эцэг/эх/-ийн нэр / Surname
ТӨМӨРДӨШ
TUMURDUSH

Үнэмлэхний дугаар / Card number
№ HC0001

Өөрийн нэр / Given name
HACAHXYY
NASANKHUU

Олгосон огноо / Date of issue
11.01.2016
Хүчинтэй хугацаа / Date of expire
11.01.2018

CONSULAR DEPARTMENT OF THE MINISTRY OF FOREIGN AFFAIRS OF MONGOLIA


ӨРГӨМЖИТ КОНСУЛЫН ҮНЭМЛЭХ
IDENTIFICATION CARD OF HONORARY CONSUL

Томилогч Улс/Sending State: Америкийн Нэгдсэн Улс/United States of America
Хүлээн авагч улс/Receiving State: Монгол/Mongolia
Консулын тойрог/Consular District: Дархан-Уул аймаг/Province of Darkhan-Uul

Signature:

Консулын газрын захирал
Director of the Consular Department

Энэхүү картыг эзэмшигч нь Монгол Улсын Гадаад хэргийн яаманд нэвтрэх эрхтэй/The bearer of this card shall be entitled to enter the premises of the Ministry of Foreign Affairs of Mongolia.

Монгол Улсын Гадаад хэргийн яам энэхүү картыг эзэмшигчид өргөмжит консулын чиг үүргээ гүйцэтгэхэд нь бүх талын туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг хөлбөрдөх эрхэм эттээдээс хүсч байна/The Ministry of Foreign Affairs of Mongolia requests all those whom it may concern to render necessary assistance and support to the bearer of this card in fulfilling his or her duties as Honorary Consul.